



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

“Жи Эс Би капитал ББСБ” ХХК-д банк бус санхүүгийн  
хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх  
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нэмж олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 22.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Жи Эс Би капитал ББСБ” ХХК-д банк бус санхүүгийн хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нэмж олгосугай.

2. Тусгай зөвшөөрөл нэмж олгосонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тус тус тэмдэглүүлж, нэмэлт өөрчлөлт оруулсан дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримт бичгийг 2014 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Жи Эс Би капитал ББСБ” ХХК /Ч.Чинбат/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000913